



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 09 сарын 16 өдөр

Дугаар А/584

Булган сум

**Хяналт шалгалтын арга хэмжээ
зохион байгуулах тухай**

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, 16.2.48 Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, 17.2.7, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3.6 дахь заалт, Байгаль эрчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны Салбарын Улсын Ерөнхий байцаагчийн баталсан 2025 оны "Ой, ойн дагалт баялаг, амьтан, байгалийн ургамлын чиглэлээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" 01/05 дугаартай удирдамж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны "Булган аймгийн 2025 оны төсөв батлах тухай" IV/26 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газар нутагт байгаль орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг 2025 оны 09 дүгээр сарын 15-ны өдрөөс 10 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд маршрутын дагуу зохион байгуулсугай.

2. Хяналт шалгалтыг зохион байгуулах замын маршрут, шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Хяналт шалгалт зохион байгуулахад шаардагдах зардал 3 414 150 (Гурван сая дөрвөн зуун арван дөрвөн мянга нэг зуун тавь) төгрөгийг Байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч (Э.Эрдэнэжаргал)-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтийг төлөвлөгөөнд заасны дагуу зохион байгуулж, шаардагдах хүн хүч, техник хэрэгслээр тухай бүрд хангаж, хамтран ажиллахыг аймгийн Байгаль орчны газрын дарга (А.Гантөмөр), Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг), Зэд-Хантай-Бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбат), Хутаг-Өндөр, Тэшиг, Сэлэнгэ сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ДУРЭВ-ОЧИР



Sugar Ажил 2025 өдөр бүр Doc/2025/Захирамж

6325010805

Аймгийн Засаг даргын 2025 оны 3 дугаар
сарын 16 -ны/ний өдрийн 168 дүгээр/дугаар
захирамжийн хавсралт



ЗЭД-ХАНТАЙ-БҮТЭЭЛИЙН НУРУУНЫ ДАРХАН ЦААЗАТ ГАЗАРТ
УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ
ЗАМЫН МАРШРУТ, ЗАРДАЛ

№	Газрын нэр	Явах км	Зарцуулах шатахуун /л/	Нэгж үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	Сэлэнгэ сумаас - Харлаг, Тариахтай, Сэлэнгэ сум- Харцай, Шавар, Ширмэн, Тайвааны нуруу, Рашаант, Цүүцийн баруун, зүүн салаа, Манхтай, Сангалтай эх, Баруун хужир, Баруун зүүн Тарвагатай, Гачуурт уул, Хандгайт - Сэлэнгэ сум	950км	A/92 - 171л	2810	480510
2	Сэлэнгэ сумаас -Тариахтайн даваа, Бодон хараач, Хантайн гурван нуруу, Шивэртын эх, Эг тарвагатайн бэлчир, Хужирын эх, Төмрөнгийн эх, Харлангийн эх, Улаан мод, Дээд, дунд, доод нарийн -Сэлэнгэ сум	980км	A/92- 176л	2810	494560
3	Сэлэнгэ сумаас -Баянгол, Хуурай ам, Бэлсэг, Бүгсий, Уурагийн эх -Сэлэнгэ сум	320км	A/92- 58л	2810	162980
БҮГД					1138050
Нийт /3 удаа/ 1138050 *3 = 3414150					